

# НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

## АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар албан бичиг шийдвэрлэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

### 🚩 Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт ирсэн бичгийг едос цахим системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 269 албан бичиг ирснийг бүртгэгдсэн байдлаар нь авч үзвэл:

- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр - 1
- Байгууллагад албан бичгээр ирж бүртгэгдсэн - 99
- Системээр бүртгэгдсэн – 169


Шийдвэрлэсэн бичгийн тоо-251, шийдвэрлэх шатанд буюу судлагдаж байгаа албан бичиг 18 байна.

Албан бичиг шийдвэрлэлийн явцад нийт 4 зөрчил бүртгэгдсэн байна. Үүнд:

- Сонгосон хугацааны зөрчил буюу явцын тэмдэглэл хөтлөөгүй 2 (ГТМААХ, ХХэлтэс),
- Систем ашиглалтын зөрчил буюу монгол бичиг хавсаргаагүй 1 (ЗТСХ), албан бичиг шийдвэрлэлтийн хугацаа буруу сонгосон 1 (ХХэлтэс)

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног байна.

2025, 2026 оны 1 дүгээр улирлын албан бичиг  
шийдвэрлэлтийн харьцуулсан график



Байгууллагад ирсэн нийт бичгийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 241 байсан бол 2026 оны 1 дүгээр улиралд 269 болон өмнөх оноос 8.7%-иар өссөн байна.

### 🚩 Явуулсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

Хүнс хөдөө аж ахуйн газар нь тайлант хугацаанд нийт 175 бичиг боловсруулж илгээсэн ба явуулсан бичигт шийдвэрлэлтийн 1 зөрчилтэй ажиллаж байна.

Явсан бичгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44 албан бичгээр буюу 20,1% иар буурсан үзүүлэлттэй байна.

Явуулсан бичгийн харьцуулалт:

2025 оны 1 дүгээр улирал		2026 оны 1 дүгээр улирал		Харьцуулалт
Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	65	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	59	9.2% иар буурсан
Газар тариалан, мал аж ахуйн хэлтэс	6	Газар тариалан, мал аж ахуйн хэлтэс	12	100% иар өссөн
Мал үржлийн алба	17	Мал үржлийн алба	14	17.6%-иар буурсан
Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	9	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	3	66.7% иар буурсан
Хяналтын хэлтэс	122	Хяналтын хэлтэс	87	28.7%-иар буурсан
Нийт	219		175	



ХЯНАСАН:  
ЗАХИРГАА ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Б.БАЯНХУТАГ

ТАЙЛАН БИЧСЭН:  
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН  
АЖИЛТАН

Т.САЙНЖАРГАЛ